

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 07-ны өдрийн
А/192 албан тоотын 2 дугаар хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024.02.07

Чойр

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагууд нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бичгээр, амаар, цахим сүлжээ, санал хүсэлтийн хайрцаг, иргэд олон нийттэй харилцах 11-11 төв болон 70543434 дугаарын нээлттэй утсаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин, ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 476 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал-7 өргөдөл, гомдол, санал хүсэлт
- Аймгийн Засаг даргад хандаж- 76 өргөдөл, гомдол, санал хүсэлт
- Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд- 36 өргөдөл, гомдол, санал хүсэлт
- Сумдын Засаг дарга нарт хандаж- 319 өргөдөл, гомдол, санал хүсэлт
- Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагуудад хандаж –38 өргөдөл, гомдол, санал хүсэлт

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хандаж ирүүлсэн нийт 7 өргөдөл, гомдол, санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг ангилан авч үзвэл:

- Тусламж дэмжлэг хүссэн -3 (дэмжлэг хүссэн 2 иргэнд 900.000 төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлсэн). 1 иргэний дэмжлэгийг төсөв санхүүгийн асуудлаас болж шийдвэрлэх боломжгүй болсон.
- Сүм хийдийн зөвшөөрөл хүсэх тухай -2 хүсэлт ирсний дагуу хуулийн дагуу судлаж үзэхэд манай орон нутагт Сүмийн үйл ажиллагаагаа явуулах байгууллага 1 байх боломжтой тул дээрх 2 сүмийн тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгох боломжгүй гэсэн хариуг албан бичгээр хүргүүлсэн.

Иргэдээс ирүүлсэн 7 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 100 хувьтай шийдвэрлэсэн бөгөөд шилжүүлсэн өргөдөл байхгүй, хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй гэж хариу өгсөн 3 өргөдөл, гомдол байна.

Аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн нийт 76 өргөдөл, гомдол, санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг ангилан авч үзвэл:

- Дэмжлэг хүссэн өргөдөл-27
- Газартай холбоотой асуудлаар-13

- Санал-10
- Замын орц, гарцын асуудлыг шийдвэрлүүлэх-10
- Гэр хүсэх тухай-8
- Байрны түрээсийн дэмжлэг хүсэх тухай-4
- Бусад/ зөвшөөрөл хүссэн, тодорхойлолт гаргуулах, цэргийн албанаас чөлөөлөгдөх гэх мэт/- 4

Аймгийн Засаг даргад ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн мөрөөр гэр хүссэн 8 өргөдлийг судлан, 3 иргэнд 6.5 сая төгрөгийн гэр олгож, 2 иргэнд гэр олгох боломжгүй. Өргөдлийн судлаж үзэхэд манай орон нутгийн харьяаллын биш, суурин байдаггүй, хөдөлмөрийн чадвараа алдаагүй ажил гэж үзэн 2 иргэний өргөдлийг шийдвэрлэх боломжгүй болсон. Мөн 3 иргэнийг өргөдлийг судалж, аймгийн Засаг даргын Тамгын газрын нөөцөд гэр байхгүй учир холбогдох газруудад болон хамтран ажиллах байгууллага, хувь хүн, иргэнтэй хамтран гэр олгох боломжтой талаар танилцуулж, гэр хүссэн иргэний бүртгэлд бүртгэсэн.

Дэмжлэг хүссэн 27 иргэнд нийт 6.0 сая төгрөгийн дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон.

Газрын асуудлаар ирүүлсэн 13 өргөдлийг хууль, журмын дагуу шийдвэрлэж ажилласан. Өвөлжилтийн маргааныг асуудлыг багийн даргатай холбогдон шийдвэрлэсэн. ААНБ-уудтай уулзалт хийн малчдын төлөөллийг оролцуулан 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт том машиныг явуулахгүй байх талаар асуудлыг шийдвэрлэсэн. Кадастрын зураг гаргуулах, газар эзэмшлийн эрхийг шилжүүлэх тухай, газар өмчлөх гэх мэт 13 өргөдлийг шийдвэрлэж ажилласан.

Замын орц, гарцын асуудлыг шийдвэрлүүлэх-10 өргөдлийг судалж, 5 өргөдлийг Замын ажил гүйцэтгэлийн компани болон иргэдтэй уулзаж замын орц, гарц гаргах боломжтой талаар шийдвэрлэсэн. Харин 5 өргөдлийг орон нутгийн замд орц, гарц гаргахад тавигдах шаардлага болон журам батлагдахтай холбоотойгоор орц, гарц гаргах боломжгүй талаар тухайн иргэнд утсаар болон биечлэн холбогдох хүмүүстэй газар дээр нь уулзаж шийдвэрлэсэн.

Байрны дэмжлэг хүссэн 3 иргэнд түрээсийн дэмжлэг болгон 3.0 сая төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон.

Аймгийн Засаг даргаас олгодог тусгай зөвшөөрөл хүссэн 1 өргөдлийг судлан Эрүүл мэндийн сайд, Хүнс, Хөдөө, аж ахуйн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан журам батлагдах хүртэлх хугацаанд шийдвэрлэх боломжгүй байсан бөгөөд 3 сайдын хамтарсан журам 10 сард батлагдан журмын дагуу архины тусгай зөвшөөрлийг 100% шийдвэрлэн ажилласан.

Аймгийн Засаг даргад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлэсэн бөгөөд бусад байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлэсэн 5, хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй гэж хариу өгсөн 7 өргөдөл, гомдол байна.

Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд- 36 өргөдөл, гомдол, талархал, санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг ангилан авч үзвэл:

- Гомдол-28
- Хүсэлт - 6
- Талархал- 2

ГОМДОЛ- иргэдээс ирүүлсэн 28 гомдлыг ангилан авч үзвэл:

- Эмчийн ёс зүй, хүнд сурталтай холбоотой - 11 гомдол
- Цагдаагийн албан хаагчидтай холбоотой- 3 гомдол
- Тусгай зөвшөөрөлтэй холбоотой- 2 гомдол
- Халамжийн мөнгө орохгүй байна- 2 гомдол
- Цахилгаан тасалсан тухай- 2 гомдол
- Вакцины 30%-ийн санхүүжилт орж ирэхгүй байгаа талаар -2 гомдол
- Бусад/Төмөр замын байрны халаалт муу, газартай холбоотой, Боловсролын байгууллагатай холбоотой, малжуулах төсөлд хамрагдах, таксины үнийн өсөлт/-6 гомдол

ХҮСЭЛТ- Иргэдээс ирүүлсэн 6 хүсэлтийг 100% шийдвэрлэн ажилласан. Үүнд: Өөрийн мэргэжлийн дагуу ажилд орохыг хүсэж байгаа боловч заавал төрийн албан хаагчийн шалгалт өгсөн хүнийг л ажилд авна гэх юм. Тэгсэн хирнээ л ажиллах хүчин хомс хөдөө ажиллах ажил эрхлэгчид байхгүй хүний дутагдалтай байх юм гэсэн хүсэлтийн дагуу Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга утсаар холбогдож Төрийн үйлчилгээний албан тушаалд шалгалт өгөхгүйгээр мэргэжлийн дагуу ажиллах боломжтой харин төрийн захиргааны албан тушаалд заавал төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн тохиолдолд ажиллах боломжтой талаар ярилцаж, асуудлыг ийдвэрлэсэн.

Мөн төрийн албан хаагч Г-ийн эх болон нөхөр барилгын компани ажиллуулдаг. Өөрийн хамаарал бүхий этгээдийнхээ гүйлгээг баталгаажуулдаг гэсэн хүсэлтийн дагуу судлан тухайн албан хаагчийг 1 сарын үндсэн цалинг 30%-иар бууруулж арга хэмжээ авч ажилласан.

Шивээговь суманд отроор явж байгаа малчдаас ирүүлсэн 4 хүсэлтийн дагуу Шивээговь сумын хувьд Бэлчээр хамгаалах журмыг сумын ИТХ-аар хэлэлцүүлж, Хууль зүй, дотоод хэргийн яамаар батлуулахаар хүргүүлсэн байна. Тухайн журам батлагдсанаар бэлчээрийн татвар авах эрх нь үүсэх талаар малчдад танилцуулсан байна. Шивээговь сумын Засаг дарга иргэдтэй холбогдож, асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.

Тээврийн цагдаад 50'000 төгрөгөөр торгуулаад 2 оноо хасуулаад хуудсаа аваад явсан. Тус торгууль нь давхардаж ороод нийт 100"000 төгрөгийн торгууль болоод жолоодох эрхийн 4 оноо хасагдсан. Чойрын тээврийн цагдаад удаа дараа хэлсэн боловч өнөөдрийг хүртэл шийдэж өгөөгүй гэсэн иргэний хүсэлтийг аймгийн Цагдаагийн хэлтэс рүү шилжүүлэн иргэний хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан.

ТАЛАРХАЛ- Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэст болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн хамт олон түргэн шуурхай үйлчилгээтэй, эелдэг найрсаг харилцаатай ажлын өндөр амжилт хүсье гэсэн иргэний талархалыг 2 байгууллага руу албан тоотоор шилжүүлэн уламжилсан.

Сумын Засаг дарга нарт хандаж ирүүлсэн нийт 319 өргөдөл, гомдол, санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг төрлөөр нь ангилбал:

- Газартай холбоотой асуудлаар- 198
- Хандив, буцалтгүй тусламж, эмчилгээний зардал мөнгөн дэмжлэг хүссэн-24
- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, хүүхэд үрчлэх тухай- 22
- Гэр хүссэн- 8

- Тусгай зөвшөөрөл- 7
- Худаг усны асуудлаар- 6
- Малжуулах төсөлд хамрагдах хүсэлт - 5
- Модны урамшуулалд хамрагдах-4
- Хүлэмж хүссэн -2
- Бусад/байрны гадна талын тохижилт, унд усны асуудал, морин уралдаан зохион байгуулах гэх мэт/- 43

Газартай холбоотой өргөдөл гаргасан 198 иргэний өргөдлийг хүлээн авч ажилласан байна. Үүнээс шинээр газар эзэмших, өмчлөх, газрын зориулалтыг өөрчлүүлэхээр ирүүлсэн 144 иргэний өргөдлийн 72 өргөдлийг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулахаар ажиллаж байгаа бол 25 иргэний газар эзэмших өргөдлийг судлахад гадаадын хөрөнгө оруулалттай компани Шивээговь сумын нутаг дэвсгэрийг эзэмшиж байгаа учраас нутгийн иргэдэд газар өмчлүүлэх боломжгүй байдалд байна. Багийн иргэдийн нийтийн хурлаар 9 иргэний Өвөлжөө, хаваржааны газрын асуудлуудыг 2024 онд хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Эрчимжсэн мал аж ахуйн бүсэд газар эзэмших хүсэлтийг 35 өргөдлийг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Газрын маргаан шийдвэрлүүлэхээр ирүүлсэн 5 иргэний өргөдлийг сумын Засаг даргын албан бичгээр мэдэгдэл хүргүүлэн 100% шийдвэрлэсэн. Мөн газрын эзэмших цэг тодорхойгүй өргөдөл тодорхой бус 14 иргэний материалыг буцаан сумын Засаг даргын албан бичгээр дараа оны газар төлөвлөлт дахин санал ирүүлэхийг зөвлөж ажилласан. Өмчлөлийн газрын талбайн хэмжээний зөрүүг арилгаж өгөх тухай 3 өргөдлийг сумын Засаг даргын захирамж гарган 100% шийдвэрлэсэн.

Газрын асуудалтай холбоотой 198 өргөдлийн хүлээн авч, 82 өргөдлийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэж, 116 өргөдлийг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хүүхэд үрчлэх -3 өргөдөл ирснийг хамтарсан багийн хурлаар шийдвэрлэн сумын Засаг даргын захирамж гарган шийдвэрлэсэн. "Гэр бүлийн тухай хууль"-ийн дагуу эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон 17 иргэнд асран хамгаалагч, 2 иргэнийг өргөдлийг судлан харгалзан дэмжигч тогтоосон сумын Засаг даргын захирамж гарган шийдвэрлэсэн.

Тамхины тусгай зөвшөөрөл хүссэн 7 иргэний өргөдлийг хүлээн авч 100% шийдвэрлэж хариуг хүргүүлсэн.

Мөн малжуулах төсөлд хамрагдах хүсэлтэй 5 иргэний өргөдлийн дагуу төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр тус 5 иргэнд нийт 106 ямаа, 168 хонь, 8 ишиг, 8 хурга олгосон.

Гэр хүссэн 8 өргөдлийг судлаж, байгалийн гамшгаас болж гэр орноо алдсан 7 иргэний хүсэлтийг судалж, гэр олгох боломжгүй мөн сумдад гэр олгох төсөв байхгүй байдаг иймд иргэдтэй уулзан мэдээлэл өгсөн. Гал түймрийн улмаас өвлийн хүйтний улиралд гэр орноо алдсан 1 иргэнд сумын Засаг даргын захирамжаар 3.600.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Сумдын Засаг даргын захирамжаар хандив, буцалтгүй тусламж, эмчилгээний зардал мөнгөн дэмжлэг хүссэн 24 өргөдлийг судлан 100 хувь шийдвэрлэн сумын Засаг даргын нөөц зардлаас 17831500 (арван долоон сая найман зуун гучин нэгэн мянга таван зуу) төгрөгийн санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлсэн.

Худаг ус шинээр гаргах 6 өргөдөл ирснийг хүлээн авч, 1 өргөдөл материал дутуу байсныг буцаасан бол өөрийн хөрөнгөөр худаг гаргах хүсэлтэй 1 иргэний өргөдлийг Байгаль орчин аялал жуулчлалын газарт шилжүүлэн шийдвэрлэсэн. Нийт хөдөөгийн малчдын дунд худаг гаргахаар ирүүлсэн 4 өргөдлийг судлан шийдвэрлүүлэхээр аймгийн 2024 оны төлөвлөлтөд тусгуулахаар аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан.

Өөрийн байгаа орчиндоо мод тарьж ургуулдаг 4 иргэн модны урамшуулалд хамрагдахаар хүсэлт ирүүлснийг 4 өргөдөл ирснийг аймгийн Байгаль орчин, аялал, жуулчлалын газарт шилжүүлэн 100% шийдвэрлэн ажилласан.

Зам дагуух айл, өрхүүдийн мал, хүүхдүүд эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэн аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, мал амьтан, хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Суурьшлийн бүсэд тог, цахилгааны асуудлыг шийдвэрлүүлэхээр ирүүлсэн иргэдийн хүсэлтийг хүлээн авч тус газруудад тог цахилгааны асуудлыг шийдвэрлэж байгаа бөгөөд 2024 оны төлөвлөлтөд тусган ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Сумдын Засаг даргад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлэсэн бөгөөд бусад байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлэсэн 111 өргөдөл, хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй гэж хариу өгсөн 39 өргөдөл, гомдол байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллагад иргэдээс нийт 38 өргөдөл, гомдол, санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг ангилан авч үзлээ.

Улсын бүртгэлийн хэлтэст

- Овог нэр өөрчлүүлэх гэрчилгээ солиулах хүсэлт-7
- Эд хөрөнгийн эзэмшигчийн нэрийг өөрчлүүлэх хүсэлт -7

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт

- Байгаль орчны үнэлгээ дүгнэлт хийлгэх – 6
- Худаг гаргах зөвшөөрөл хүсэх тухай- 4
- Өр барагдуулах-1

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт:

- Газрын асуудалтай холбоотой- 5

Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт

- Халамжийн хүүхдийн мөнгийг шийдвэрлэх- 4
- ОУ-ын тэмцээнд оролцох хүүхдэд дэмжлэг үзүүлэх хүсэлт-1

Боловсрол, шинжлэх ухааны газарт:

- Анги танхимын цэвэрлэгээтэй холбоотой- 2
- Багшийн ёс зүйтэй холбоотой-1

Аймгийн Засаг даргын дэргэдэх байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлэсэн бөгөөд бусад байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлэсэн 5, хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй гэж хариу өгсөн өргөдөл, гомдол байхгүй байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 476 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэсэн. 116 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлэн шийдвэрлэсэн бол 48 өргөдлийг хуулийн хүрээнд судлан шийдвэрлэх боломжгүй талаар хариу хүргүүлсэн.

Нийт өргөдлийг ирсэн байгууллагын хүрээнд хүснэгтээр үзүүлбэл.

№	Байгууллага, албан тушаалтны нэр	Ирсэн өргөдөл, тоо	Шийдвэрлэлтийн хувь	Шийдвэрлэх хугацаа болоогүй, тоо	Хугацаанд нь шийдвэрлээгүй, тоо	Хугацаа хоцорч шийдвэрлэсэн, тоо
1	Аймгийн ИТХ	7	100	-	-	-
2	АЗДТГ	76	100	-	-	-
3	11-11 төвөөс шилжүүлсэн	36	100	-	-	-
4	Шивээговь сум	61	100	-	-	-
5	Сүмбэр сум	226	100	-	-	-
6	Баянтал сум	32	100	-	-	-
7	Улсын бүртгэлийн хэлтэс	14	100	-	-	-
8	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	11	100	-	-	-
9	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	5	100	-	-	-
10	Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт	5	100	-	-	-
11	Боловсрол, шинжлэх ухааны газарт	3	100	-	-	-
Нийт/дундаж		476	100	-	-	-

Баталгаажуулсан:

Говьсүмбэр аймгийн Засаг даргын орлогч

Б.Наранбаатар

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

М.Анхбаяр

Тайлагнасан:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Ц.Отгончимэг

Өргөдөл гомдол, санал хүсэлт хариуцсан мэргэжилтэн

Б.Гарамсүрэн



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
ИЛТГЭХ ХУУДАС**

**Аймгийн төрийн байгууллагуудад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас
ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн
шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай**

2024.02.08

Чойр хот

Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго, хамрах хүрээ, арга зүй:

Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд 2023 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, түүний мөрөөр авсан арга хэмжээ, үр дүнг тодорхойлох зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд 2023 онд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн жилийн эцсийн тайлан, мэдээтэй танилцах, үр дүнг нягтлах, нотлох, асууж тодруулах арга замаар хийсэн бөгөөд холбогдох байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд анхаарах асуудлаар зөвлөмж боловсруулсан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:

1. Аймаг, сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, агентлагуудын хувь өргөдөл, гомдлыг биечлэн, утсаар болон цахим хэлбэрээр, албан бичгээр тус тус хүлээн авч, шийдвэрлэж байгаа нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэгт заасны дагуу иргэдээс өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангасан байна. Мөн тус хуулийн 7.1.2 дахь хэсэгт заасан харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг заавал хүлээн авах үүргийг бүрэн биелүүлж ажилласан. 2023 онд биеэр 394, утсаар 6, цахимаар 1, 11-11 төвөөр 36, албан бичгээр 39, нийт 476 өргөдөл хүлээн авсанаас төрлөөр нь авч үзвэл 28 гомдол, 448 хүсэлт байна.

2022 оны жилийн эцсийн байдалтай харьцуулан үзэхэд 2023 онд хүлээн авсан өргөдөл гомдлын тоо 2.9 хувиар нэмэгдсэн байна. (2022 онд нийт 462 өргөдөл, гомдол)

2022 онд 1 гомдол, 2 санал, 459 хүсэлт хүлээн авч байсан бол 2023 онд 28 гомдол, 448 хүсэлт хүлээн авсанаас харахад иргэдээс ирүүлсэн гомдлын тоо нэмэгдсэн байна.

2. 2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 11 төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 476 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлсэн бөгөөд хуулийн хугацаанд хянан үзэж 100% хариуг хүргүүлсэн байна. Үр дүнг дараах хүснэгтээр харуулав.

№	Байгууллага, албан тушаалтны нэр	Ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлтийн хувь
1	Аймгийн ИТХ	7	100
2	АЗДТГ	76	100
3	11-11 төвөөс шилжүүлсэн	36	100
4	Шивээговь сум	61	100
5	Сүмбэр сум	226	100
6	Баянтал сум	32	100
7	Улсын бүртгэлийн хэлтэс	14	100
8	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	11	100
9	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	5	100
10	Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт	5	100
11	Боловсрол, шинжлэх ухааны газарт	3	100
Нийт/дундаж		476	100

Мөн 476 өргөдлөөс 116 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлэн шийдвэрлэсэн нь нийт өргөдлийн 24.3 хувийг, 54 өргөдлийг хуулийн хүрээнд судлан шийдвэрлэх боломжгүй талаар хариу хүргүүлсэн нь нийт өргөдлийн 11.7 хувийг тус тус эзэлж байна.

Өргөдөл, гомдлын хариуг 2022 онд албан бичгээр 237, цахимаар 1, утсаар 65, биечлэн 159 хүрүүлж байсан бол 2023 онд албан бичгээр 199, цахимаар 12, утсаар 98, биечлэн 167 иргэнд хариу хүргүүлсэн байгаагаас харахад иргэдэд цахимаар болон утсаар хариу хүргүүлж байгаа нь өргөдөл гаргасан иргэнд хугацааны хувьд хурдан шуурхай үйлчлэх боломжийг нэмэгдүүлсэн байна.

Гэвч 2022 онд 9 өргөдлийг холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж байсан бол 2023 онд 116 болж нэмэгдсэн нь өргөдөл гомдлыг үндэслэлтэй шийдвэрлэх, хариу хүргүүлэх боломжийг олгож байгаа ч шат дамжлагыг нэмэгдүүлсэн байна.

Үүнээс гадна 2022 онд 10 иргэнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх боломжгүй талаар мэдэгдэж байсан бол 2023 онд 54 болж нэмэгдсэн нь тухайн албан тушаалтны бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй өргөдөл гомдол 116, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй өргөдөл байхгүй, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар гаргаагүй 54 өргөдөл гомдол ирүүлсэн байгаатай холбоотой байна.

Тухайлбал Сүм хийдийн зөвшөөрөл хүссэн-2, гэр хүссэн-7, авто замын орц, гарц гаргуулах хүсэлт-5, газар эзэмших-25, газар эзэмших цэг тодорхой бус өргөдөл-14, дэмжлэг хүссэн -1 зэрэг шийдвэрлэх боломжгүй өргөдлүүд ирсэн байна.

3. Өргөдөл, гомдол гаргагчийн зүгээс өргөдөл, гомдлын шийдвэрийг зөвшөөрөөгүйтэй холбоотой дээд шатны байгууллага, албан тушаалтан болон хянан шийдвэрлэх үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргасан болон өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой гомдол гараагүй байна.

4. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нэгтгэн улирал тутамд Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ЗГХЭГ газарт хүргүүлж хэвшсэн бөгөөд аймгийн албан ёсны www.govisumber.gov.mn цахим хуудсаар мэдээлж байна.

Дүгнэлт:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд 2023 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:



1. Говьсүмбэр аймгийн төрийн байгууллага, албан тушаалтан иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг нээлттэй хүлээн авч, хуульд заасан хугацаанд буюу 30 хоногийн дотор шийдвэрлэн хариуг хүргүүлж хэвшсэн байна.
2. 2023 онд иргэдээс ирүүлсэн гомдлын тоо өссөн бөгөөд мөн бусад байгууллагад шилжүүлэн шийдвэрлэсэн, шийдвэрлэх боломжгүй талаар хариу мэдэгдсэн өргөдөл, гомдлын тоо нэмэгдсэн байна.
3. Өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэхтэй холбоотой дээд шатны байгууллага, албан тушаалтан, үүрэг бүхий захиргааны байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй байна.
4. Говьсүмбэр аймгийн төрийн байгууллагууд, албан тушаалтанууд "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг бүрэн хэрэгжүүлэх хүрээнд иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг аймгийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлж байна.

Зөвлөмж:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль"-ийг сурталчлах, тус хуулийн 7 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарах.
2. Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудлаар гаргасан өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавих.
3. Өргөдөл, гомдлын агуулгад судалгаа хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжүүлэх.
4. Өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх үйл явцыг ил тод, хурдан шуурхай болгож, цахимжуулах арга хэмжээний үр дүнг сайжруулах.

ИЛТГЭХ ХУУДАС ХЯНАСАН:
АЗДТГАЗРЫН ХШҮХ-ИЙН ДАРГА

М.АНХБАЯР

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
АЗДТГАЗРЫН ХШҮХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

О.БОЛОРМАА